



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ЯАМ**

Засгийн газрын III байр, Бага тойруу 44,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: 26 22 27, Факс: (976-51) 26 37 27,
Цахим шуудан: letter@mse.gov.mn,
Цахим хуудас: www.mse.gov.mn

2026.04.17 № 03/2166

танил _____ -ны № _____ -т

**БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САНГИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
М.ТӨРТӨГТОХ ТАНАА**

Боловсролын сайд, Сангийн сайдын
хамтарсан 2026 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн
"Тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах тухай"
А/05,86 дугаар тушаалыг хүргүүлж байна.

Тушаалын хэрэгжилтийг ханган ажиллана уу.
Хавсралт ... хуудастай.

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА** **Д.РЕНЧИНДОРЖ**



1426181498

БОЛОВСРОЛЫН САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2026 оны 04 дугаар
сарын 16 ны өдөр

Дугаар А/05,86

Улаанбаатар

Тушаалын хавсралтад өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээл эргэн төлүүлэх журам"-ын 11.1 дэх хэсэг, 2026 оны "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 94 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Гэрээний үлгэрчилсэн загварыг шинэчлэн батлах тухай" 2025 оны Боловсролын сайд, Сангийн сайдын А/571/212 дугаар хамтарсан тушаалын

1 дүгээр хавсралтаар баталсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээл олгох, зээлийг эргэн төлүүлэх гэрээ"-ний 6.1.2. "улирлын голч дүн тухайн сургалтын байгууллагын авбал зохих үнэлгээний 75 хувиас доошгүй; гэснийг" ... улиралд судалсан хичээлүүд нь тухайн үнэлгээний системийн дагуу хангалттай буюу түүнээс дээш түвшинд үнэлэгдсэн" гэж

2 дугаар хавсралтаар баталсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлэг олгох гэрээ"-ний "5.1.1 өмнөх улирлын голч дүн тухайн сургалтын байгууллагын авбал зохих үнэлгээний 75 хувиас доошгүй гэснийг дараагийн улиралд дэвшин суралцах эрхээ авсан; гэж

4 дүгээр хавсралтаар баталсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг олгох гэрээ"-ний 5.1.1. "улирлын голч дүн авбал зохих үнэлгээний 75 хувиас доошгүй; гэснийг" ... улиралд судалсан хичээлүүд нь тухайн үнэлгээний системийн дагуу хангалттай буюу түүнээс дээш түвшинд үнэлэгдсэн" гэж;

6 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид монгол улсын засгийн газрын тэтгэлэг олгох гэрээ"-ний 5.1.1. "төрийн албан хаагчийн хичээлийн жилийн өмнөх улирлын голч дүн авбал зохих үнэлгээний 75 хувиас доошгүй; гэснийг 5.1.1. "төрийн албан хаагчийн өмнөх улиралд судалсан хичээлүүд нь тухайн үнэлгээний системийн дагуу хангалттай буюу түүнээс дээш түвшинд үнэлэгдсэн" гэж тус тус өөрчилсүгэй.

2. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчтай гэрээний үлгэрчилсэн загвараар гэрээ байгуулж санхүүжилтийн тооцоо хийж ажиллахыг Боловсролын зээлийн сангийн Ажлын алба (М.Төртогтох)-нд даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсролын яамны Дээд болон мэргэжлийн боловсролын бодлого зохицуулалтын газар (Н.Нарангэрэл), Санхүү, хөрөнгө оруулалтын газар (С.Должинсүрэн), Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газар (М.Санжаадорж)-т тус тус үүрэг болгосугай.



Боловсролын сайд, Сангийн сайдын
2026 оны 04 дугаар сарын 16-ны
өдрийн А/05/86 хамтарсан
тушаалын нэгдүгээр хавсралт

**ГАДААДЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД
СУРАЛЦАГЧИД СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ ОЛГОХ,
ЗЭЭЛИЙГ ЭРГЭН ТӨЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**

20 оны дугаар
сарын -ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Энэ гэрээг нэг талаас Боловсролын зээлийн сан (цаашид "сан" гэх), (регистрийн дугаар: 5053145), түүнийг төлөөлж Ажлын албаны дарга (эцэг, /эх/-ийн нэр), (өөрийн нэр), нөгөө талаас гадаадын дээд боловсролын сургалтын байгууллага (цаашид "сургалтын байгууллага" гэх)-д суралцагч аймаг/хот, сум/дүүрэг, баг/хороо, гудамж/хороолол, байр/хашаа тоотод оршин суух, регистрийн дугаартай, (эцэг /эх/-ийн нэр) (өөрийн нэр), хамтран үүрэг гүйцэтгэгч аймаг/хот, сум/дүүрэг, баг/хороо, гудамж/хороолол, байр/хашаа тоотод оршин суух, регистрийн дугаартай, (эцэг/эх/-ийн нэр) (өөрийн нэр) (хамтад нь "талууд" гэх) нар Иргэний хуулийн 242, 281 дүгээр зүйлүүд, холбогдох бусад зүйл, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 5 дугаар зүйл болон холбогдох бусад зохицуулалтыг зохицуулалтыг үндэслэн харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ГОЛ НӨХЦӨЛ

1.1. Энэ гэрээний зорилго нь Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээлийг эргэн төлүүлэх журам" (цаашид "журам" гэх)-ын дагуу суралцагчид авсан тэтгэлгийн хэмжээг харгалзан сургалтын төлбөрийн үлдэх дүнгээр сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээл (цаашид "зээл" гэх)-ийг олгох, түүнийг эргэн төлүүлэхтэй холбоотой талуудын эрх, үүргийг тодорхойлж, холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Суралцагч улсын сургалтын байгууллагад (бакалавр, магистр, доктор (сайдын тушаалаар баталгаажсан боловсролын зэрэгт хамаарахыг сонгож бичих))-ын үндсэн хөтөлбөрөөр, мэргэжлээр, жилийн хугацаанд суралцаж, төгсөнө.

1.3. Гэрээний мөнгөн дүнг олгосон зээлийн нийт дүнгээр тооцож, сургалтын төлбөрийг шилжүүлэхэд сургалтын байгууллага болон суралцагчаас ирүүлсэн нэхэмжлэлд заасан гадаад улсын мөнгөн тэмдэгтийн тухайн өдрийн Монголбанкны ханшийг баримтална.

1.4. Суралцагчид олгож буй сургалтын төлбөрийн зээлд хүү тооцохгүй бөгөөд энэ нь төрөөс үзүүлж буй хөнгөлөлттэй санхүүгийн дэмжлэг гэж үзнэ. Суралцагчид олгох сургалтын төлбөрийн зээл нь хүүгүй, хөнгөлөлттэй байна.

1.5. Зээл олгох нийт хугацаа нь энэ гэрээний 6.2.1, 6.2.3-т зааснаас бусад тохиолдолд Боловсролын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний тушаалаар баталсан суралцах хугацаанаас хэтрэхгүй байна.

1.6. Суралцагч энэ гэрээний нэгдүгээр хавсралт болох Зээлийн эргэн төлөлтийн хуваарь (цаашид "хуваарь" гэх)-ийн дагуу зээлээ төлнө. Суралцагч зээлээ төлөөгүй тохиолдолд хамтран үүрэг гүйцэтгэгч зээл төлөх үүргийг гүйцэтгэнэ.

1.7. Суралцагч гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангахаар энэ гэрээний 2 дугаар хавсралт болох Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ (цаашид "Барьцааны гэрээ" гэх)-нд заасан үл хөдлөх эд хөрөнгө (цаашид "барьцааны зүйл" гэх)-ийг барьцаалсан болно. Барьцааны гэрээ нь энэ гэрээний салшгүй хэсэг байна.

1.8. Барьцааны зүйл суралцагчийн, эсхүл түүнтэй хамаарал бүхий гуравдагч этгээдийн өмчлөлийнх байна.

1.9. Барьцааны зүйлийн үнэ нь суралцагчийн авах нийт зээлийн үнийн дүнгийн 51 хувиас доошгүй байх бөгөөд үнэлгээг хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ.

1.10. Гэрээний хугацаа хичээлийн жилийн улирлын үргэлжлэх хугацаатай адил байна. Цаашид энэ хугацаа талууд энэ гэрээний 1.6-д заасан хуваарийн дагуу зээлээ төлж дуусах хүртэлх хугацаагаар хүчин төгөлдөр үргэлжилнэ.

1.11. Энэ гэрээний 1.10-т заасан хугацаа дууссан нь үүргээ биелүүлээгүй суралцагчаас зээлийг төлөхгүй байх үндэслэл болохгүй бөгөөд энэ хугацаа зээлийг бүрэн төлж дуусах хүртэлх хугацаагаар хүчин төгөлдөр үргэлжилнэ.

1.12. Энэ гэрээний 1.11-т заасан үүргээ биелүүлэх хүртэл суралцагч, хамтран үүрэг гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хүчин төгөлдөр хэвээр байна.

1.13. Зээлийг хуваарьт заасан хугацаанаас өмнө бүрэн төлж болно.

1.14. Гэрээнд заасан хүндэтгэн үзэх шалтгааныг журамд заасны дагуу ойлгоно.

ХОЁР. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Суралцагч дараах эрхтэй:

2.1.1 сургалтын явц, чанар, зээлийн эргэн төлөлттэй холбоотой болон гэрээтэй холбоотой бусад асуудлаар санал, хүсэлтээ илэрхийлэх, сангаас мэдээлэл авах, төлбөрийн гүйлгээний баримт авах;

2.1.2 гэрээний үүргээ биелүүлэхийг сангаас шаардах;

2.1.3 зээлийг бүрэн төлж дууссан тохиолдолд барьцааны зүйлийг чөлөөлүүлэх;

2.1.4 хууль тогтоомж, журмын хүрээнд харилцан тохиролцсон бусад.

2.2. Суралцагч дараах үүрэгтэй:

2.2.1. суралцагчаас үл хамаарсан шалтгаанаар суралцаж байгаа мэргэжлийн чиглэл өөрчлөгдсөнөөс бусад тохиолдолд сонгосон мэргэжлийг солихгүй, сургалтын байгууллага хооронд шилжин суралцахгүй байх;

2.2.2. хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд сургалтын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлж, гэрээний 1.5-д заасан хугацаанд төгсөх;

2.2.3. сурлагын дүн, холбогдох бусад мэдээллийг хичээлийн жилийн улирал бүр, шаардлагатай тохиолдолд сангаас шаардсан тухай бүр сургуулийн болон өөрийн цахим шуудангаас тухайн хөтөлбөрийн албаны цахим шууданд ирүүлэх, гэрээний биелэлтийг дүгнэхэд санг шаардлагатай мэдээллээр хангах;

2.2.4. суралцагч, эсхүл хамтран үүрэг гүйцэтгэгч нь хичээлийн жилийн улирал бүр гэрээг дүгнүүлэх, тооцоо нийлсэн актыг баталгаажуулах;

2.2.5. давтан судлах эсхүл гадаадын сургалтын байгууллагын сургалтын байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэлээр авсан хичээлийг W(withdrawn) үнэлгээгээр цуцалсан, өөр сургалтын байгууллагад судалсан, хэлний түвшин ахиулах зорилгоор нэмэлтээр сонгосон хичээлийн сургалтын төлбөрийг өөрөө хариуцан төлөх;

2.2.6. сангаас тавьсан шаардлагыг биелүүлэх, сургалтын байгууллагын дүрэм, журмыг мөрдөх;

2.2.7. гэнэтийн осол, гэмтлийн улмаас амь насаа алдах, эрүүл мэндэд нь хохирол учрах, хөдөлмөрийн чадвар алдах, тооцоолоогүй санхүүгийн эрсдэлд орохоос хамгаалах зорилгоор эрсдэлийн даатгалаар даатгуулах;

2.2.8. Барьцааны гэрээ байгуулах, энэ гэрээ болон барьцааны гэрээний хэрэгжилтэд сангаас хяналт тавих боломжоор хангах, барьцааны зүйлийг байгалийн болон гэнэтийн осол аюулаас хамгаалах арга хэмжээг авч даатгуулсан байна.

2.2.9. барьцааны зүйлийг үнэлүүлэх, түүнийг арчлан хамгаалахад гарсан зардал, барьцааны зүйлтэй холбоотойгоор төлсөн татвар, хураамж, төлбөр болон гэрээний дагуу хийгдэх аливаа ажиллагаа (худалдан борлуулах, шүүх, өмгөөлөл, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа)-тай холбогдон гарах зардлыг төлөх;

2.2.10. зээлийг хуваарийн дагуу хугацаанд нь бүрэн төлөх;

2.2.11. барьцааны гэрээнд заасан тохиолдол бий болоход барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг тэргүүн ээлжид хангах;

2.2.12. барьцааны зүйл нь Барьцааны гэрээний 2.6-д заасан барьцаагаар хангагдах шаардлагыг бүрэн хангахад хүрэлцэхгүй тохиолдолд бусад хөрөнгөөрөө төлөх;

2.2.13. энэ гэрээний 6.5-д заасан үндэслэлээр гэрээг цуцалсан тохиолдолд олгосон нийт зээлийг 5.2-т заасан хугацаанд буцаан төлөх;

2.2.14. төгсөлтийн бүртгэлийг диплом олгосон өдрөөс хойш 2 сарын дотор хийлгэх;

2.2.15. хууль тогтоомж, журмын хүрээнд харилцан тохиролцсон бусад.

2.2.16. Хамтран үүрэг гүйцэтгэгч нь зээл төлөх талаар суралцагчтай нэгэн адил эрх, үүрэгтэй байна. Суралцагч зээл төлөх үүргээ биелүүлээгүй тохиолдолд зээл төлөх үүргийг гүйцэтгэнэ. Энэ гэрээний 2.6.4-т заасан тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг хангана.

2.2.17. Суралцагч энэ гэрээний 2.2.2-т заасан хүндэтгэн үзэх шалтгааныг эрх бүхий байгууллагын шийдвэрээр нотолсон байна.

2.3. Сан дараах эрхтэй:

2.3.1. гэрээний үүргээ биелүүлэхийг суралцагч, хамтран үүрэг гүйцэтгэгчээс шаардах;

2.3.2. Суралцагч гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол хууль, журамд нийцүүлэн гэрээг түдгэлзүүлэх, цуцлах, дуусгавар болгох арга хэмжээг авах;

2.3.3. хууль тогтоомж, журмын хүрээнд харилцан тохиролцсон бусад.

2.4. Сан дараах үүрэгтэй:

2.4.1. зээлийг хичээлийн жилийн улирлаар тооцож, холбогдох шийдвэр, байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэлд үндэслэн сургалтын байгууллагын дансанд шилжүүлэх, шаардлагатай тохиолдолд тайлбар, тодруулга авах;

2.3.4. суралцагчийн мэдээллийг Монголбанкны Зээлийн мэдээллийн санд бүртгүүлж, (нийлүүлэх) барьцаа бүртгэсэн талаарх лавлагааг суралцагчийн хувийн хэрэгт хавсаргана;

2.3.5. суралцагчийн голч дүн, шилжилт хөдөлгөөн, зээл олголтын талаар дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж, талуудыг үнэн зөв мэдээллээр хангах;

2.3.6. гэрээний биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах, хичээлийн жилийн улирал тутам дүгнэх, гэрээг түдгэлзүүлэх, сунгах, суралцагч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд өөрийн санаачилгаар гэрээг цуцалж, зээл олгохыг зогсоох, өмнө олгосон зээлийг нэхэмжлэх, эргэн төлүүлэх, суутгах, барьцааны зүйлээр гэрээнд заасны дагуу үүргийн гүйцэтгэлийг хангуулах, суралцагч үүргээ биелүүлээгүй тохиолдолд хамтран үүрэг гүйцэтгэгчээс үүргийн гүйцэтгэлийг шаардах, төлүүлэх, бусад үндэслэлээр гэрээг дуусгавар болгох;

2.3.7. энэ гэрээний үүрэг дуусгавар болсон үед барьцааны зүйлийг чөлөөлөх;

2.3.8. хүний хувийн мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглах, хадгалах;

2.3.9. хууль тогтоомж, журмын хүрээнд харилцан тохиролцсон бусад.

ГУРАВ. ГЭРЭЭ СУНГАЛТ

3.1. Сан хичээлийн жилийн улирал бүр гэрээг дүгнэж, үүрэг биелсэн үед сунгана.

№	Хичээлийн жилийн улирал	Гэрээ дүгнэсэн огноо	Гэрээний хүчинтэй хугацаа	Сангийн Ажлын албаны дарга, гарын үсэг, тэмдэг	Суралцагч (хамтран үүрэг гүйцэтгэгч)-ийн нэр, гарын үсэг
1					
2					
3					
4					
5					
6					
7					
8					
9					
10					
11					
12					

ДӨРӨВ. ЗЭЭЛ ОЛГОЛТ

4.1. Сан гэрээний хугацаанд олгосон зээл (олгосон валютаар)-ийг тухайн улиралд баталгаажуулна.

№	Хичээлийн жилийн улирал	Голч дүн	Олгосон зээлийн хэмжээ	Суралцагчийн (хамтран үүрэг гүйцэтгэгчийн) нэр, гарын үсэг	Сангийн мэргэжилтэн нэр, гарын үсэг,	Тайлбар
1						
2						
3						
4						
5						

6						
7						
8						
9						
10						
11						
12						

ТАВ. ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ

5.1. Суралцагч зээлийг сургууль төгссөнөөс хойш 6 сарын дараагаас эхлэн зээлийг эргэн төлж 20 хүртэлх жилийн хугацаанд дуусгана. Эргэн төлөлтийн хуваарийг Монголбанкны Зээлийн мэдээллийн санд нийлүүлнэ.

5.2. Суралцагч энэ гэрээний 2.2.14-т заасан хугацаанд ирж бүртгүүлэхдээ зээлийн эргэн төлөх хуваарийг сантай тохиролцон тогтооно. (суралцагчийн авсан зээлийн хэмжээ, суралцсан хугацааг үндэслэн тооцох)

5.3. Сан энэ гэрээний 2.2.14-т заасан хугацаанд ирж бүртгүүлэхийг суралцагч эсхүл хамтран үүрэг гүйцэтгэгчид мэдэгдэнэ. Заасан хугацаанд ирж бүртгүүлэхээс зайлсхийвэл бүртгүүлэх хугацаа дууссан даруйд сан энэ гэрээний 5.2-т заасан хуваарийг баталж зээл төлөх хугацааг эхлүүлнэ. Зээлийн эргэн төлөх хуваарийг суралцагч эсхүл хамтран үүрэг гүйцэтгэгчид санд бүртгэлтэй цахим шуудан болон "И-Монголиа" цахим системээр мэдэгдэнэ.

5.4. Зээлийг хуваарийн дагуу сангийн Төрийн сан дахь тоот дансанд зээл олгосон валютаар төлнө.

5.5. Суралцагч энэ гэрээний 5.2-т заасан хуваарийн дагуу зээл төлөх үүргээ биелүүлэхгүй байгаа тохиолдолд хамтран үүрэг гүйцэтгэгч зээл төлөх үүргийг гүйцэтгэнэ.

5.6. Зээлийн эргэн төлөх хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар төгсөгч 5 хүртэлх жилээр нэг удаа сунгаж болно. Хүндэтгэн үзэх шалтгааныг эрх бүхий байгууллагын шийдвэрээр нотолсон байна.

5.7. Төгсөгч суралцсан мэргэжлээрээ гадаадад туршлага хуримтлуулах зорилгоор 3 хүртэлх жил ажиллаж болох бөгөөд энэ нь зээлийн эргэн төлөлтийн хугацаанд өөрчлөлт оруулах үндэслэл болохгүй.

ЗУРГАА. ГЭРЭЭГ СУНГАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ЦУЦЛАХ, ДУУСГАВАР БОЛГОХ

6.1. Гэрээг хичээлийн жилийн улирлаар дүгнэж, дараах тохиолдолд сунгана:

6.1.1. Суралцагчийн өмнөх улиралд судалсан хичээлүүд нь тухайн үнэлгээний системийн дагуу хангалттай буюу түүнээс дээш түвшинд үнэлэгдсэн байх;

6.1.2. гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлсэн байх.

6.2. Гэрээг хичээлийн жилийн улирлаар дүгнэж, дараах тохиолдолд түдгэлзүүлж, зээл олгохыг зогсооно:

6.2.1. суралцагч жирэмсний, амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй, эсхүл хүндэтгэн үзэх шалтгааны улмаас 1 сараас дээш хугацаагаар суралцах боломжгүй болсныг эрх бүхий байгууллагын шийдвэрээр нотолсон тохиолдолд;

6.2.2. суралцагч дүнгийн шаардлага хангаагүй;

6.2.3. суралцагч сургалтын байгууллагаас хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөө авсан;

6.3. Суралцах хугацаанд гэрээг 2-оос дээшгүй удаа түдгэлзүүлж болох ба түдгэлзүүлсэн нийт хугацаа 2 жилээс хэтрэхгүй байна. Хугацаа хэтэрсэн тохиолдолд гэрээг цуцална.

6.4. Гэрээг дүгнэж, дараах тохиолдолд аль нэг талын санаачилгаар цуцална:

6.4.1. суралцагч гэрээнд заасан суралцах улс, сургалтын байгууллага, мэргэжил өөрчилсөн;

6.4.2. суралцуулах шийдвэрээр баталсан хугацаанд төгсөөгүй, түдгэлзүүлэх хугацаа хэтэрсэн;

6.4.3. суралцагч сургалтын байгууллагаас хасагдсан, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гарсан, шалтгаангүйгээр чөлөө авсан, чөлөөний хугацаа сунгасан;

6.4.4. суралцагч хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь баримтаар тогтоогдсон;

6.4.5. суралцагч суралцах хугацаандаа гэмт хэрэгт холбогдож, гэм буруутайг нь шүүхээс тогтоосон.

6.5. Энэ гэрээний 6.4-д заасан үндэслэлээр гэрээг цуцлах тохиолдолд суралцагч олгосон нийт зээлийг 2 жилийн дотор тэтгэлэг олгосон валютаар буцаан төлнө. Энэ тухай мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор буцаан төлөх хуваарийг гэрээний 5.2-т заасан нөхцөлөөр суралцагчтай тохиролцож тогтооно.

6.6. Суралцагч буцаан төлөх үүргээ биелүүлээгүй тохиолдолд энэ үүргийг хамтран үүрэг гүйцэтгэгч хариуцан гүйцэтгэнэ.

6.7. Гэрээг түдгэлзүүлэх, цуцлахад талууд баримт үйлдэнэ. Дараах үндэслэлээр гэрээ дуусгавар болно:

6.7.1. гэрээний хугацаа дуусаж, талууд хүлээсэн үүргээ биелүүлсэн (зээлээ төлсөн болон бусад үүргээ биелүүлсэн);

6.7.2. барьцааны зүйлийг шүүхийн журмаар худалдан борлуулж, гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулсан;

6.7.3. суралцагч нас барсан, нас барсан гэж шүүхээс зарласан, сураггүй алга болсонд, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүй гэж шүүхээс тооцсон, хөдөлмөрийн чадвараа алдсаныг Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэрээр тогтоож, даатгалын гэрээнд заасны дагуу гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулсан, даатгалын гэрээний дагуу үүргийн гүйцэтгэлийг бүрэн хангуулах боломжгүй, эсхүл үүргийн гүйцэтгэлийг хангуулах боломжгүй тохиолдолд тус тус хамтран үүрэг гүйцэтгэгч үүргийн гүйцэтгэлийг хангасан;

6.7.4. аль нэг талын санаачилгаар хугацаа дуусахаас өмнө гэрээг цуцалж, гэрээний үүргийг биелүүлсэн.

6.8. Энэ гэрээнд заасан "хөдөлмөрийн чадвараа алдсан" гэснийг журамд заасны дагуу ойлгоно.

6.9. Энэ гэрээний 6.8-д заасан үндэслэлээр гэрээ дуусгавар болгоход талууд гэрээ дүгнэсэн баримт үйлдэж, барьцааны зүйлийг чөлөөлнө.

6.10. Сан энэ гэрээний 6.5-д заасан гэрээг цуцлах нөхцөл байдал үүссэн даруйд цуцлаагүй нь энэ эрхээ хэрэгжүүлэхээс татгалзсан гэж үзэхгүй.

ДОЛОО. БУСАД

- 7.1. Гэрээг дөрвөн хувь үйлдэх бөгөөд хувь тус бүр адил хүчинтэй байна.
- 7.2. Энэ гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга/ тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
- 7.3. Энэ гэрээний дагуу үйлдэх Зээлийн эргэн төлөлтийн хуваарь, Барьцааны гэрээ, түүний өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.
- 7.4. Энэ гэрээ болон Барьцааны гэрээг хүчин төгөлдөр болсноор суралцагчид зээл олгоно.
- 7.5. Энэ гэрээний дагуу үйлдэх баримтын загварыг сангийн Ажлын албаны дарга баталж, салшгүй хэсэг болно.
- 7.6. Энэ гэрээний 5.2-т заасан хуваарь, гэрээ, түүний өөрчлөлтийг зөрчсөн нь энэ гэрээг зөрчсөнтэй нэгэн адил тооцогдоно.
- 7.7. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр холбогдох хууль тогтоомж, журмын хүрээнд нэмэлт, гэрээнд өөрчлөлт оруулж болно. Холбогдох нэмэлт, өөрчлөлт нь энэ гэрээний 1.5 дахь хэсэгт хамаарахгүй.
- 7.8. Гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.
- 7.9. Талуудын хооронд гэрээнд заасан асуудлаар маргаан гарвал зөвшилцлийн замаар шийдвэрлэхийг урьтал болгох бөгөөд зөвшилцөлд хүрч эс чадвал шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Суралцагч:	Санг төлөөлж: Ажлын албаны дарга	Хамтран үүрэг гүйцэтгэгч:
.....
(эцэг/эх-ийн нэр)	(эцэг/эх-ийн нэр)	(эцэг/эх-ийн нэр)
.....
(өөрийн нэр)	(өөрийн нэр)	(өөрийн нэр)
.....
(гарын үсэг)	(гарын үсэг)	(гарын үсэг)
.....
(утас)	(утас)	(утас)

Боловсролын сайд, Сангийн сайдын
2026 оны 04 дугаар сарын 16-ны
өдрийн 8.105, 76 хамтарсан
тушаалын хоёрдугаар хавсралт

ГАДААДЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД СУРАЛЦАГЧИД МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ГЭРЭЭ

20 оны дугаар
Улаанбаатар хот
сарын -ны өдөр

Дугаар ...

Энэ гэрээг нэг талаас Боловсролын зээлийн сан (цаашид "сан" гэх), (регистрийн дугаар: 5053145), түүнийг төлөөлж сангийн Ажлын албаны дарга (эцэг /эх/-ийн нэр) (өөрийн нэр), нөгөө талаас гадаадын дээд боловсролын сургалтын байгууллага (цаашид "сургалтын байгууллага" гэх)-д суралцагч (сонгоно уу: *Нийт сум, хороо бүрээс шалгарсан¹, Олон улсын олимпиадад медальт байрт шалгарсан²*) аймаг/ хот, сум/дүүрэг, баг/хороо, гудамж/хороолол, байр/хашаа тоотод оршин суух, (регистрийн дугаар)-тай, (эцэг /эх/-ийн нэр) (өөрийн нэр), суралцагчийн харьяалагдах аймаг/нийслэлийн Засаг дарга (цаашид "Засаг дарга", хамтад нь "талууд" гэх) албан тушаалтай, (эцэг /эх/-ийн нэр) (өөрийн нэр) нар харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ГОЛ НӨХЦӨЛ

1.1. Энэ гэрээний зорилго нь Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээл эргэн төлүүлэх журам" (цаашид "журам" гэх)-ын дагуу гадаадын сургалтын байгууллагад суралцагчид Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлэг (сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардал (дотуур байрны болон хүнсний зардал) (цаашид "тэтгэлэг" гэх) олгохтой холбоотой талуудын эрх, үүргийг тодорхойлж, холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Суралцагч Улсын сургалтын байгууллагад бакалаврын хөтөлбөрөөр, мэргэжлээр, жилийн хугацаанд суралцаж, төгсөнө.

1.3. Гэрээний мөнгөн дүнг гэрээний хугацаанд олгосон тэтгэлгийн нийт дүнгээр тооцож, сургалтын төлбөр болон амьжиргааны зардал шилжүүлэхэд сургалтын байгууллага болон суралцагчаас ирүүлсэн нэхэмжлэлд заасан гадаад улсын мөнгөн тэмдэгтийн тухайн өдрийн Монголбанкнаас тогтоосон ханшийг баримтална.

¹ Энэ суралцагчтай сан болон түүнийг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга 3 талт гэрээ байгуулна.

² Энэ суралцагчтай сан 2 талт гэрээ байгуулна.

1.4.Тэтгэлэг олгох нийт хугацаа нь энэ гэрээний 5.2.1-д зааснаас бусад тохиолдолд Боловсролын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний тушаалаар баталсан суралцах хугацаанаас хэтрэхгүй байна.

1.5.Гэрээний хугацаа хичээлийн жилийн улирлын үргэлжлэх хугацаатай адил байна. Цаашид энэ гэрээний дагуу суралцагчид ногдуулсан аливаа үүргийг гүйцэтгэж дуусах хүртэл хугацаагаар хүчин төгөлдөр үргэлжилнэ.

1.6.Гэрээнд заасан хүндэтгэн үзэх шалтгааныг журамд заасны дагуу ойлгоно.

ХОЁР. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Суралцагч дараах эрхтэй:

2.1.1. сургалтын явц, чанар болон гэрээтэй холбоотой бусад асуудлаар Засаг дарга, санд санал, хүсэлтээ илэрхийлэх, төлбөрийн гүйлгээний баримт авах;

2.1.2. гэрээний үүргээ биелүүлэхийг сан болон Засаг даргаас шаардах;

2.1.3. хууль тогтоомж, журмын хүрээнд харилцан тохиролцсон бусад.

2.2. Суралцагч дараах үүрэгтэй:

2.2.1. суралцагчаас үл хамаарсан шалтгаанаар суралцаж байгаа мэргэжлийн чиглэл өөрчлөгдсөнөөс бусад тохиолдолд сонгосон мэргэжлийг солихгүй, сургалтын байгууллага хооронд шилжин суралцахгүй байх;

2.2.2. хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд сургалтын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлж, гэрээний 1.4-д заасан хугацаанд төгсөх;

2.2.3. аливаа гэнэтийн осол, гэмтлийн улмаас амь насаа алдах, эрүүл мэндэд нь хохирол учрах, хөдөлмөрийн чадвар алдах, тооцоолоогүй санхүүгийн эрсдэлд орохоос хамгаалах зорилгоор эрсдлийн даатгалаар даатгуулах;

2.2.4. сурлагын дүн, холбогдох бусад мэдээллийг хичээлийн жилийн улирал бүр, шаадлагатай тохиолдолд сангаас шаардсан тухай бүр сургуулийн болон өөрийн цахим хаягнаас тухайн хөтөлбөрийн албан ёсны цахим хаяг руу ирүүлэх, гэрээний биелэлтийг дүгнэхэд санг шаардлагатай мэдээллээр хангах;

2.2.5. суралцагч, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч нь хичээлийн жилийн улирал бүр гэрээг дүгнүүлэх, тооцоо нийлсэн актыг баталгаажуулах;

2.2.6. давтан судлах эсхүл гадаадын сургалтын байгууллагын сургалтын байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэлээр авсан хичээлийг W(withdrawn) үнэлгээгээр цуцалсан, өөр сургалтын байгууллагад судалсан, хэлний түвшин ахиулах зорилгоор нэмэлтээр сонгосон хичээлийн сургалтын төлбөрийг өөрөө хариуцан төлөх;

2.2.7. сан болон Засаг даргаас тавьсан шаардлагыг биелүүлэх, сургалтын байгууллагын дүрэм, журмыг мөрдөх;

2.2.8. гэрээний 5.4-д заасан үндэслэлээр гэрээг цуцалсан тохиолдолд олгосон санхүүжилтийг заасан хугацаанд буцаан төлөх;

2.2.9. төгсөөд диплом олгосон өдрөөс хойш 2 сарын дотор санд бүртгүүлэх, 1 жилийн дотор ажилд орох;

2.2.10. төгсөөд аймаг (сумаас шалгарсан бол), нийслэлд (хорооноос шалгарсан бол), мэргэжлээрээ, 5-аас доошгүй жил тогтвортой, тасралтгүй ажиллах;

2.2.11. хууль тогтоомж, журмын хүрээнд харилцан тохиролцсон бусад.

2.3. Суралцагч энэ гэрээний 2.2.2-т заасан хүндэтгэн үзэх шалтгаанаа эрх бүхий байгууллагын шийдвэрээр нотолно.

2.4. Энэ гэрээнд заасан ажиллах шаардлагыг байгууллагын тодорхойлолт, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн баримтаар баталгаажуулна.

2.5. Байгууллага өөрчлөн байгуулагдсан (нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх), зохион байгуулалтын бүтэц нь өөрчлөгдсөн, татан буугдсан, эсхүл өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар албан тушаалын орон тоо нь хасагдсаны улмаас өөр ажил, албан тушаалд сэлгэн ажиллах тохиолдолд өмнө ажилласан хугацааг ажилласан хугацаанд оруулан тооцно.

2.6. Сан дараах эрхтэй:

2.6.1. гэрээтэй холбоотой асуудлаар суралцагч болон Засаг даргад санал, хүсэлтээ илэрхийлэх;

2.6.2. гэрээний үүргээ биелүүлэхийг суралцагч, итгэмжлэгдсэн төлөөлөгч болон Засаг даргаас шаардах;

2.6.3 суралцагчаас шаардлагатай тохиолдолд тайлбар, тодруулга авах;

2.6.4. хууль тогтоомж, журмын хүрээнд харилцан тохиролцсон бусад.

2.7. Сан дараах үүрэгтэй:

2.7.1. тэтгэлгийг хичээлийн жилийн улирлаар тооцож, холбогдох шийдвэр, байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэлд үндэслэн сургалтын төлбөрийг сургалтын байгууллагын дансанд, дотуур байрны зардлыг хамаарах байгууллагын дансанд, хүнсний зардлыг суралцагчийн дансанд тус тус тогтоосон хугацаанд шилжүүлэх;

2.7.2. суралцагчийн голч дүн, шилжилт хөдөлгөөн, тэтгэлэг, олголтын талаар дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж, талуудыг үнэн зөв мэдээллээр хангах;

2.7.3. гэрээний биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах, хичээлийн жилийн улирал тутам дүгнэх, гэрээг түдгэлзүүлэх, сунгах, суралцагч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд сангийн санаачилгаар гэрээг цуцалж, тэтгэлэг олгохыг зогсоох, өмнө олгосон санхүүжилтийг нэхэмжлэх, эргэн төлүүлэх, суутгах, журамд заасан үндэслэлээр гэрээг дуусгавар болгох;

2.7.4. хүний хувийн мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглах;

2.7.5. хууль тогтоомж, журмын хүрээнд харилцан тохиролцсон бусад.

2.8. Засаг дарга дараах эрхтэй:

2.8.1. гэрээтэй холбоотой асуудлаар суралцагч болон санд санал, хүсэлтээ илэрхийлэх;

2.8.2. суралцагчид олгох тэтгэлгийн талаарх тайлбар, нэмэлт мэдээллийг сангаас авах;

2.8.3. тэтгэлгийг тогтоосон хугацаанд шилжүүлэхийг сангаас шаардах;

2.8.4. гэрээний үүргээ биелүүлэхийг суралцагч болон сангаас шаардах;

2.8.5. суралцагч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах саналыг санд тавьж шийдвэрлүүлэх;

2.8.6. хууль тогтоомж, журмын хүрээнд харилцан тохиролцсон бусад.

2.9. Засаг дарга дараах үүрэгтэй:

2.9.1. суралцагчийг төгссөнөөс хойш 1 жилийн дотор мэргэжлийн дагуу ажлын байраар хангах, дэмжлэг үзүүлж ажиллах;

2.9.2. гэрээний хэрэгжилтийг хангуулах, биелэлтэд хяналт тавих;

2.9.3. гэрээг дүгнэхэд болон бусад шаардлагатай тохиолдолд санг шаардлагатай мэдээллээр хангах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;

2.9.4. хүний хувийн мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглах;

2.9.5. хууль тогтоомж, журмын хүрээнд харилцан тохиролцсон бусад.

5								
6								
7								
8								
9								
...								

ТАВ. ГЭРЭЭГ СУНГАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ЦУЦЛАХ, ДУУСГАВАР БОЛГОХ

5.1. Гэрээг хичээлийн жилийн улирлаар дүгнэж, дараах тохиолдолд сунгана:

5.1.1. Суралцагч дараагийн улиралд дэвшин суралцах эрхээ авсан байх;

5.1.2. гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлсэн байх.

5.2. Гэрээг хичээлийн жилийн улирлаар дүгнэж, дараах тохиолдолд түдгэлзүүлж, тэтгэлэг олгохыг зогсооно:

5.2.1. Суралцагч жирэмсний, амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй, эсхүл хүндэтгэн үзэх шалтгааны улмаас 1 сараас дээш хугацаагаар суралцах боломжгүй болсныг эрх бүхий байгууллагын шийдвэрээр нотолсон тохиолдолд;

5.2.2. суралцагч дүнгийн шаардлага хангаагүй;

5.2.3. суралцагч сургалтын байгууллагаас хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөө авсан.

5.3. Суралцах хугацаанд гэрээг 2 удаа түдгэлзүүлж болох ба түдгэлзүүлэх нийт хугацаа 1 жил хүртэл байна. Хугацаа хэтэрсэн тохиолдолд гэрээг цуцална.

5.4. Гэрээг дүгнэж, дараах тохиолдолд аль нэг талын санаачлагаар цуцална:

5.4.1. суралцагч гэрээнд заасан суралцах улс, сургалтын байгууллага, мэргэжил өөрчилсөн;

5.4.2. суралцуулах шийдвэрээр баталсан хугацаанд төгсөөгүй, түдгэлзүүлэх хугацаа хэтэрсэн;

5.4.3. суралцагч сургалтын байгууллагаас хасагдсан, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гарсан, шалтгаангүйгээр чөлөө авсан, чөлөөний хугацаа сунгасан;

5.4.4. суралцагч хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь баримтаар тогтоогдсон;

5.4.5. суралцагч суралцах хугацаандаа гэмт хэрэгт холбогдож, гэм буруутайг нь шүүхээс тогтоосон;

5.4.6. суралцагч төгсөөд жирэмсний, амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй, хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд 1 жилийн дотор ажилд ороогүй, эсхүл энэ гэрээний 2.2.9-д заасны дагуу ажиллаагүй;

5.4.7. суралцагч төгсөөд аймаг (сумаас шалгарсан бол), нийслэлд (хорооноос шалгарсан бол) мэргэжлийн ажил санал болгоход өөрийн хүсэлтээр татгалзсан;

5.4.8. суралцагч хөтөлбөрөөс татгалзсан;

5.4.9. гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй.

5.5. Гэрээг түдгэлзүүлэх, цуцлахад талууд баримт үйлдэж, гэрээнд хавсаргана.

5.6. Гэрээний 5.4-т заасан үндэслэлээр цуцлах тохиолдолд суралцагч олгосон нийт тэтгэлгийг 2 жилийн дотор буцаан төлнө. Энэ тухай мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор буцаан төлөх хуваарийг суралцагчтай тохиролцож тогтооно.

5.7. Дараах үндэслэлээр гэрээ дуусгавар болно:

5.7.1. гэрээний хугацаа дуусч, талууд хүлээсэн үүргээ биелүүлсэн байх;

5.7.2. суралцагч нас барсан, нас барсан гэж шүүхээс зарласан, сураггүй алга болсонд, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүй гэж шүүхээс тооцсон, хөдөлмөрийн чадвараа алдсаныг Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэрээр тогтоож, даатгалын гэрээнд заасны дагуу гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулсан, эсхүл үүргийн гүйцэтгэлийг хангуулах боломжгүй тохиолдолд тус тус итгэмжлэгдсэн төлөөлөгч үүргийн гүйцэтгэлийг хангасан;

5.7.3. аль нэг талын санаачилгаар хугацаа дуусахаас өмнө гэрээг цуцалж, гэрээний үүргийг биелүүлсэн.

5.8. Энэ гэрээнд заасан "хөдөлмөрийн чадвараа алдсан" гэснийг журамд заасны дагуу ойлгоно.

5.9. Энэ гэрээний 5.6-д заасны дагуу өмнө олгосон санхүүжилтийг буцаан төлүүлэх тохиолдолд тухайн төлбөр төлөх үүрэг үүссэн өдрийн Монголбанкны ханшаар тооцож төлнө.

5.10. Сан энэ гэрээний 5.4-т заасан гэрээг цуцлах нөхцөл байдал үүссэн даруйд цуцлаагүй нь энэ эрхээ хэрэгжүүлэхээс татгалзсан гэж үзэхгүй.

5.11. Засаг дарга энэ гэрээний 2.9.1-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд түүнд журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ЗУРГАА. БУСАД

6.1. Гэрээг гурван хувь үйлдэх бөгөөд хувь тус бүр адил хүчинтэй байна.

6.2. Энэ гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга/ тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

6.3. Гэрээ хүчин төгөлдөр болсноор суралцагчид санхүүжилтийг олгоно.

6.4. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр холбогдох хууль тогтоомж, журмын хүрээнд гэрээнд өөрчлөлт оруулж болно. Холбогдох өөрчлөлт нь энэ гэрээний 1.6 дахь хэсэгт хамаарахгүй.

6.5. Гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

6.6. Талуудын хооронд гэрээнд заасан асуудлаар маргаан гарвал зөвшилцлийн замаар шийдвэрлэхийг урьтал болгох бөгөөд зөвшилцөлд хүрч эс чадвал шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Суралцагч:

Санг төлөөлж:
Ажлын албаны дарга

Аймаг/ нийслэлийн Засаг
дарга:

.....
(эцэг/эх-ийн нэр)

.....
(эцэг/эх-ийн нэр)

.....
(эцэг/эх-ийн нэр)

.....
(өөрийн нэр)

.....
(өөрийн нэр)

.....
(өөрийн нэр)

.....
(гарын үсэг)

.....
(гарын үсэг)

.....
(гарын үсэг)

.....
(утасны дугаар)

Итгэмжлэгдсэн төлөөлөгч:

.....
(эцэг/эх-ийн нэр)

.....
(өөрийн нэр)

.....
(гарын үсэг)

20 ... оны ... дугаар сарын ... өдөр

Боловсролын сайд, Сангийн сайдын
2026 оны 04 дугаар сарын 16 -ны
өдрийн А/05, 26
хамтарсан тушаалын дөрөвдүгээр
хавсралт

ГАДААДЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД СУРАЛЦАГЧИД ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ГЭРЭЭ

20 оны дугаар
сарын -ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Энэ гэрээг нэг талаас Боловсролын зээлийн сан (цаашид "сан" гэх), (регистрийн дугаар: 5053145), түүнийг төлөөлж сангийн Ажлын албаны дарга (эцэг/эх/-ийн нэр), (өөрийн нэр), нөгөө талаас гадаадын дээд боловсролын сургалтын байгууллага (цаашид "сургалтын байгууллага" гэх)-д суралцагч аймаг/ хот, сум/дүүрэг, баг/ хороо, гудамж/хороолол, байр/хашаа тоотод оршин суух, (регистрийн дугаар)-тай, (эцэг /эх/-ийн нэр) (өөрийн нэр), (цаашид "суралцагч", хамтад нь "талууд" гэх)нар харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ГОЛ НӨХЦӨЛ

1.1. Энэ гэрээний зорилго нь Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээлийг эргэн төлүүлэх журам" (цаашид "журам" гэх)-ын дагуу тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцагчид, техникийн боловсролын сургалтын байгууллагын олон улсын хөтөлбөрийг дотоодын сургуульд төгсөж, тухайн мэргэжлийн чиглэлээрээ гадаадын сургалтын байгууллагад үндсэн хөтөлбөрөөр дэвшин суралцагчид Монгол Улсын Засгийн газрын тэтгэлэг болон Засгийн газар хоорондын тэтгэлэг (цаашид "тэтгэлэг" гэх) олгохтой холбоотой талуудын эрх, үүргийг тодорхойлж, холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Суралцагч Улсын сургалтын байгууллагад (дэд бакалавр, бакалавр, магистр, доктор (сайдын тушаалаар баталгаажсан боловсролын зэрэгт хамаарахыг сонгож бичих))-ын үндсэн хөтөлбөрөөр, мэргэжлээр, жилийн хугацаанд суралцаж, төгсөнө.

1.3. Энэхүү гэрээгээр суралцагчид (сургалтын төлбөр, амьжиргааны зардал (дотуур байрны, хүнсний зардал) тэтгэлгийн төрлийг тухайн хөтөлбөрт хамаарахыг сонгож бичих) -ны тэтгэлэг олгоно.

1.4. Гэрээний мөнгөн дүнг гэрээний хугацаанд олгосон тэтгэлгийн нийт дүнгээр тооцож, сургалтын төлбөр болон амьжиргааны зардал шилжүүлэхэд сургалтын байгууллага болон суралцагчаас ирүүлсэн нэхэмжлэлд заасан гадаад улсын мөнгөн тэмдэгтийн тухайн өдрийн Монголбанкнаас тогтоосон ханшийг баримтална.

1.5.Тэтгэлэг олгох нийт хугацаа нь энэ гэрээний 2.2.2-д зааснаас бусад тохиолдолд Боловсролын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний тушаалаар баталсан суралцах хугацаанаас хэтрэхгүй байна.

1.6. Гэрээний хугацаа хичээлийн жилийн улирлын үргэлжлэх хугацаатай адил байна. Цаашид энэ гэрээний дагуу суралцагчид ногдуулсан аливаа үүргийг гүйцэтгэж дуусах хүртэл хугацаагаар хүчин төгөлдөр үргэлжилнэ.

1.7. Гэрээнд заасан хүндэтгэн үзэх шалтгааныг журамд заасны дагуу ойлгоно.

ХОЁР. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Суралцагч дараах эрхтэй:

2.1.1.сургалтын явц, чанар болон гэрээтэй холбоотой асуудлаар санд санал, хүсэлтээ илэрхийлэх, төлбөрийн гүйлгээний баримт авах;

2.1.2.гэрээний үүргээ биелүүлэхийг сангаас шаардах;

2.1.3.хууль тогтоомж, журмын хүрээнд харилцан тохиролцсон бусад.

2.2. Суралцагч дараах үүрэгтэй:

2.2.1.суралцагчаас үл хамаарсан шалтгаанаар суралцаж байгаа мэргэжлийн чиглэл өөрчлөгдсөнөөс бусад тохиолдолд сонгосон мэргэжлийг солихгүй, сургалтын байгууллага хооронд шилжин суралцахгүй байх;

2.2.2.хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд сургалтын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлж, гэрээний 1.5-д заасан хугацаанд төгсөх;

2.2.3.аливаа гэнэтийн осол, гэмтлийн улмаас амь насаа алдах, эрүүл мэндэд нь хохирол учрах, хөдөлмөрийн чадвар алдах, тооцоолоогүй санхүүгийн эрсдэлд орохоос хамгаалах зорилгоор эрсдэлийн даатгалаар даатгуулах;

2.2.4.сурлагын дүн, холбогдох бусад мэдээллийг хичээлийн жилийн улирал бүр, шаардлагатай тохиолдолд сангаас шаардсан тухай бүр сургуулийн болон өөрийн цахим шуудангаас тухайн хөтөлбөрийн албаны цахим шуудан руу ирүүлэх, гэрээний биелэлтийг дүгнэхэд санг шаардлагатай мэдээллээр хангах;

2.2.5.суралцагч, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч нь хичээлийн жилийн улирал бүр гэрээг дүгнүүлэх, тооцоо нийлсэн актыг баталгаажуулах;

2.2.6.давтан судлах эсхүл гадаадын сургалтын байгууллагын сургалтын байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэлээр авсан хичээлийг W(withdrawn) үнэлгээгээр цуцалсан, өөр сургалтын байгууллагад судалсан, хэлний түвшин ахиулах зорилгоор нэмэлтээр сонгосон хичээлийн сургалтын төлбөрийг өөрөө хариуцан төлөх;

2.2.7.сангаас тавьсан шаардлагыг биелүүлэх, сургалтын байгууллагын дүрэм, журмыг мөрдөх;

2.2.8.гэрээний 5.4-д заасан үндэслэлээр гэрээг цуцалсан тохиолдолд олгосон санхүүжилтийг заасан хугацаанд буцаан төлөх;

2.2.9.төгсөөд, диплом олгосон өдрөөс хойш 2 сарын дотор санд бүртгүүлэх, 1 жилийн дотор ажилд орох.

2.2.10.төгсөөд эх орондоо, мэргэжлээрээ, 5-аас доошгүй жил тасралтгүй ажиллах;

2.2.11.хууль тогтоомж, журмын хүрээнд харилцан тохиролцсон бусад.

2.3.Суралцагч энэ гэрээний 2.2.2-т заасан хүндэтгэн үзэх шалтгааныг эрх бүхий байгууллагын шийдвэрээр нотолно.

2.4.Энэ гэрээнд заасан тогтоосон хугацаанд ажиллах шаардлагыг байгууллагын тодорхойлолт, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн баримтаар баталгаажуулна.

2.5.Сан дараах эрхтэй.

- 2.5.1 гэрээтэй холбоотой асуудлаар суралцагчид санал, хүсэлт гаргах;
- 2.5.2 гэрээний үүргээ биелүүлэхийг суралцагчаас шаардах;
- 2.5.3 суралцагчаас шаардлагатай тохиолдолд тайлбар, тодруулга авах;
- 2.5.4 хүний хувийн мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглах;
- 2.5.5 хууль тогтоомж, журмын хүрээнд харилцан тохиролцсон бусад.

2.6. Сан дараах үүрэгтэй:

2.6.1. тэтгэлгийг хичээлийн жилийн улирлаар тооцож, холбогдох шийдвэр, байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэлд үндэслэн сургалтын төлбөрийг сургалтын байгууллагын дансанд, дотуур байрны зардлыг хамаарах байгууллагын дансанд, хүнсний зардлыг суралцагчийн дансанд тус тус тогтоосон хугацаанд шилжүүлэх,

2.6.2. суралцагчийн голч дүн, шилжилт хөдөлгөөн, тэтгэлэг олголтын талаар дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж, талуудыг үнэн зөв мэдээллээр хангах;

2.6.3. гэрээний биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах, хичээлийн жилийн улирал тутам дүгнэх, гэрээг түдгэлзүүлэх, сунгах, суралцагч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд сангийн санаачилгаар гэрээг цуцалж, тэтгэлэг олгохыг зогсоох, өмнө олгосон санхүүжилтийг нэхэмжлэх, эргэн төлүүлэх, суутгах, журамд заасан үндэслэлээр гэрээг дуусгавар болгох;

2.6.4. хууль тогтоомж, журмын хүрээнд харилцан тохиролцсон бусад.

2.7. Суралцагчтай биечлэн харилцах боломжгүй тохиолдолд аймаг/ хот, сум/ дүүрэг, баг/ хороо, гудамж/ хороолол, байр/хашаа, тоотод оршин суух, эцэг, /эх/-ийн нэр), (өөрийн нэр) нь түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч суралцагчийн үүргийг хүлээх болно.

2.8. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн бүрэн эрх Иргэний хуулийн 62 дугаар зүйлийн 62.3-т заасны дагуу итгэмжлэлийн үндсэн дээр үүснэ. Энэхүү итгэмжлэл нь гэрээний хавсралт байна.

ГУРАВ. ГЭРЭЭ СУНГАЛТ

3.1. Сан хичээлийн жилийн улирал бүр гэрээг дүгнэж, үүрэг биелсэн үед сунгана.
(суралцагчийн суралцах санхүүжилтийн төрлөөс хамаарч олгох зардал ялгаатай тул холбогдох зардлыг тэмдэглэх)

№	Хичээлийн жилийн улирал	Гэрээ дүгнэсэн огноо	Гэрээний хүчинтэй хугацаа	Сангийн Ажлын албаны дарга, гарын үсэг, тэмдэг	Суралцагч (итгэмжлэгдсэн төлөөлөгч)-ийн нэр, гарын үсэг
1					
2					
3					
4					
5					
6					
7					
8					
9					
10					

11						
12						

ДӨРӨВ. ТЭТГЭЛЭГ ОЛГОЛТ

4.1 Сан гэрээний хугацаанд олгосон тэтгэлгийг (олгосон валютаар)-ийг тухайн улиралд баталгаажуулна.

№	Хичээлийн жилийн улирал	Голч дүн	Хамаарах зардал			Суралцагч (итгэмжлэгдсэн төлөөлөгч) чийн нэр, гарын үсэг	Сангийн мэргэжил-тэний нэр, гарын үсэг	Тайлбар
			Сургалтын төлбөрийн хэмжээ	Дотуур байрын зардлын хэмжээ	Хүнсний зардлын хэмжээ			
1								
2								
3								
4								
5								
6								
7								
8								
...								

ТАВ. ГЭРЭЭГ СУНГАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ЦУЦЛАХ, ДУУСГАВАР БОЛГОХ

5.1. Гэрээг хичээлийн жилийн улирлаар дүгнэж, дараах тохиолдолд сунгана:

5.1.1. Монгол Улсын Засгийн газрын тэтгэлгээр тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцагч, Засгийн газар хоорондын тэтгэлгээр суралцагч бол хичээлийн жилийн өмнөх улиралд судалсан хичээлүүд нь тухайн үнэлгээний системийн дагуу хангалттай буюу түүнээс дээш түвшинд үнэлэгдсэн"

5.1.2. Монгол Улсын Засгийн газрын тэтгэлгээр техникийн боловсролын сургалтын байгууллагын олон улсын хөтөлбөрийг дотоодын сургуульд төгсөж, тухайн мэргэжлийн чиглэлээрээ гадаадын сургалтын байгууллагад үндсэн хөтөлбөрөөр дэвшин суралцагч бол хичээлийн жилийн дараагийн улиралд дэвшин суралцах эрхээ авсан байх;

5.1.3. гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлсэн байх.

5.2. Гэрээг хичээлийн жилийн улирлаар дүгнэж, дараах тохиолдолд түдгэлзүүлж, тэтгэлэг олгохыг зогсооно:

5.2.1. Суралцагч жирэмсний, амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй, эсхүл хүндэтгэн үзэх шалтгааны улмаас 1 сараас дээш хугацаагаар суралцах боломжгүй болсныг эрх бүхий байгууллагын шийдвэрээр нотолсон тохиолдолд;

5.2.2. дүнгийн шаардлага хангаагүй;

5.2.3. суралцагч сургалтын байгууллагаас хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөө авсан.

5.3. Суралцах хугацаанд гэрээг 2 удаа түдгэлзүүлж болох ба түдгэлзүүлэх нийт хугацаа 2 жил хүртэл байна. Хугацаа хэтэрсэн тохиолдолд гэрээг цуцална.

5.4. Гэрээг дүгнэж, дараах тохиолдолд аль нэг талын санаачилгаар цуцална:

5.4.1. суралцагч гэрээнд заасан суралцах улс, сургалтын байгууллага, мэргэжил өөрчилсөн;

5.4.2. суралцуулах шийдвэрээр баталсан хугацаанд төгсөөгүй, түдгэлзүүлэх хугацаа хэтэрсэн;

5.4.3. суралцагч сургалтын байгууллагаас хасагдсан, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гарсан, шалтгаангүйгээр чөлөө авсан, чөлөөний хугацаа сунгасан;

5.4.4. суралцагч хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь баримтаар тогтоогдсон;

5.4.5. суралцагч суралцах хугацаандаа гэмт хэрэгт холбогдож, гэм буруутайг нь шүүхээс тогтоосон;

5.4.6. суралцагч төгсөөд жирэмсний, амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй, хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд 1 жилийн дотор ажилд ороогүй, эсхүл энэ гэрээний 2.2.10-д заасны дагуу ажиллаагүй.

5.4.7 гэрээгээр заасан үүргээ биелүүлээгүй байх.

5.5. Гэрээг түдгэлзүүлэх, цуцлахад талууд баримт үйлдэж, гэрээнд хавсаргана.

5.6. Гэрээний 5.4-т заасан үндэслэлээр цуцалсан тохиолдолд суралцагч олгосон нийт тэтгэлгийг 2 жилийн дотор тэтгэлэг олгосон валютаар буцаан төлнө. Энэ тухай мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор буцаан төлөх хуваарийг суралцагчтай тохиролцож тогтооно.

5.7. Дараах үндэслэлээр гэрээ дуусгавар болно:

5.7.1 гэрээний хугацаа дуусаж, талууд хүлээсэн үүргээ биелүүлсэн байх;

5.7.2. суралцагч нас барсан, нас барсан гэж шүүхээс зарласан, сураггүй алга болсонд, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүй гэж шүүхээс тооцсон, хөдөлмөрийн чадвараа алдсаныг Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэрээр тогтоосны дагуу даатгалын гэрээнд заасны дагуу гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулсан;

5.7.3. аль нэг талын санаачилгаар хугацаа дуусахаас өмнө гэрээг цуцалж, гэрээний үүргийг биелүүлсэн.

5.8. Энэ гэрээнд заасан "хөдөлмөрийн чадвараа алдсан" гэснийг холбогдох хууль, журамд заасны дагуу ойлгоно.

5.9. Сан энэ гэрээний 5.4-т заасан гэрээг цуцлах нөхцөл байдал үүссэн даруйд цуцлаагүй нь энэ эрхээ хэрэгжүүлэхээс татгалзсан гэж үзэхгүй.

ЗУРГАА. БУСАД

- 6.1. Гэрээг гурван хувь үйлдэх бөгөөд хувь тус бүр адил хүчинтэй байна.
- 6.2. Энэ гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга/ тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
- 6.3. Гэрээ хүчин төгөлдөр болсноор суралцагчид санхүүжилтийг олгоно.
- 6.4. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр холбогдох хууль тогтоомж, журмын хүрээнд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Холбогдох нэмэлт, өөрчлөлт нь энэ гэрээний 1.5 дахь хэсэгт хамаарахгүй.
- 6.5. Гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.
- 6.6. Талуудын хооронд гэрээнд заасан асуудлаар маргаан гарвал зөвшилцлийн замаар шийдвэрлэхийг урьтал болгох бөгөөд зөвшилцөлд хүрч эс чадвал шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Суралцагч:	Санг төлөөлж: Ажлын албаны дарга	Итгэмжлэгдсэн төлөөлөгч:
.....
(эцэг/эх-ийн нэр)	(эцэг/эх-ийн нэр)	(эцэг/эх-ийн нэр)
.....
(өөрийн нэр)	(өөрийн нэр)	(өөрийн нэр)
.....
(гарын үсэг)	(гарын үсэг)	(гарын үсэг)
.....
(утас)	(утас)	(утас)

20 ... оны ... дугаар сарын ... өдөр

Боловсролын сайд, Сангийн сайдын
2026 оны 09 дугаар сарын 16-ны
өдрийн А.105, 86 хамтарсан
тушаалын зургаадугаар хавсралт

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ГЭРЭЭ**

20 ... оны ... дугаар
Улаанбаатар хот
сарын ... -ны өдөр

Дугаар

Энэ гэрээг нэг талаас Боловсролын зээлийн сан (цаашид "сан" гэх), (регистрийн дугаар: 5053145), түүнийг төлөөлж сангийн Ажлын албаны дарга эцэг, /эх/-ийн нэр), (өөрийн нэр), нөгөө талаас гадаадын дээд боловсролын сургалтын байгууллага (цаашид "сургалтын байгууллага" гэх)-д төрийн албан хаагч аймаг/ хот, сум/дүүрэг, баг/ хороо, гудамж/хороолол, байр/хашаа тоотод оршин суух, (регистрийн дугаар)-тай, эцэг, /эх/-ийн нэр), (өөрийн нэр), төрийн алба хаагчийн харьяалагдах төрийн байгууллага (цаашид хамтад нь "талууд" гэх), түүнийг төлөөлж албан тушаалтай эцэг, /эх/-ийн нэр), (өөрийн нэр) нар харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ГОЛ НӨХЦӨЛ

1.1. Энэ гэрээний зорилго нь Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын төрийн албан хаагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээлийг эргэн төлүүлэх журам" (цаашид "журам" гэх)-ын дагуу тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр төрийн албан хаагчид сургалтын төлбөр, дотуур байрны зардал (цаашид "тэтгэлэг" гэх) олгохтой холбоотой талуудын эрх, үүргийг тодорхойлж, холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Төрийн албан хаагч улсын сургалтын байгууллагад, сар (хэлний бэлтгэлтэй эсэхийг сайдын тушаалаар баталгаажсан тохиолдолд 12 сар хүртэлх хугацааг бичих), (магистр, доктор (сайдын тушаалаар баталгаажсан боловсролын зэрэгт хамаарахыг сонгож бичих))-ын үндсэн хөтөлбөрөөр, мэргэжлээр жилийн хугацаанд суралцаж, төгсөнө.

1.3. Гэрээний мөнгөн дүнг гэрээний хугацаанд олгосон тэтгэлгийн нийт дүнгээр тооцож, сургалтын төлбөр болон дотуур байрны зардал шилжүүлэхэд сургалтын байгууллага болон суралцагчаас ирүүлсэн нэхэмжлэлд заасан гадаад улсын мөнгөн тэмдэгтийн тухайн өдрийн Монголбанкнаас тогтоосон ханшийг баримтална.

1.4. Тэтгэлэг олгох нийт хугацаа нь энэ гэрээний 5.2-т зааснаас бусад тохиолдолд Боловсролын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний тушаалаар баталсан суралцах хугацаанаас хэтрэхгүй байна.

1.5. Гэрээний хугацаа хичээлийн жилийн улирлын үргэлжлэх хугацаатай адил байна. Цаашид энэ гэрээний дагуу төрийн албан хаагчид ногдуулсан аливаа үүргийг гүйцэтгэж дуусах хүртэл хугацаагаар хүчин төгөлдөр үргэлжилнэ.

1.6. Гэрээнд заасан хүндэтгэн үзэх шалтгааныг журамд заасны дагуу ойлгоно.

ХОЁР. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Төрийн албан хаагч дараах эрхтэй:

2.1.1. сургалтын явц, чанар болон гэрээтэй холбоотой асуудлаар санд санал, хүсэлтээ илэрхийлэх, төлбөрийн гүйлгээний баримт авах;

2.1.2. гэрээний үүргээ биелүүлэхийг сан, төрийн байгууллагаас шаардах;

2.1.3. хууль тогтоомж, журмын хүрээнд харилцан тохиролцсон бусад.

2.2. Төрийн албан хаагч дараах үүрэгтэй:

2.2.1. төрийн албан хаагчаас үл хамаарсан шалтгаанаар суралцаж байгаа мэргэжлийн чиглэл өөрчлөгдсөнөөс бусад тохиолдолд сонгосон мэргэжлээр солихгүй, сургалтын байгууллага хооронд шилжин суралцахгүй байх;

2.2.2. хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд сургалтын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлж, гэрээний 1.4-д заасан хугацаанд төгсөх;

2.2.3. аливаа гэнэтийн осол, гэмтлийн улмаас амь насаа алдах, эрүүл мэндэд нь хохирол учрах, хөдөлмөрийн чадвар алдах, тооцоолоогүй санхүүгийн эрсдэлд орохоос хамгаалах зорилгоор эрсдэлийн даатгалаар даатгуулах;

2.2.4. сурлагын дүн, холбогдох бусад мэдээллийг хичээлийн жилийн улирал бүр, шаардлагатай тохиолдолд сангаас шаардсан тухай бүр сургуулийн болон өөрийн цахим шуудангаас тухайн хөтөлбөрийн албаны цахим шуудан руу ирүүлэх, гэрээний биелэлтийг дүгнэхэд санг шаардлагатай мэдээллээр хангах;

2.2.5. төрийн албан хаагч, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч нь хичээлийн жилийн улирал бүр гэрээг дүгнүүлэх, тооцоо нийлсэн актыг баталгаажуулах;

2.2.6. давтан судлах эсхүл гадаадын сургалтын байгууллагын сургалтын байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэлээр авсан хичээлийг W(withdrawn) үнэлгээгээр цуцалсан, өөр сургалтын байгууллагад судалсан, хэлний түвшин ахиулах зорилгоор нэмэлтээр сонгосон хичээлийн сургалтын төлбөрийг өөрөө хариуцан төлөх;

2.2.7. сан болон төрийн байгууллагаас тавьсан шаардлагыг биелүүлэх, сургалтын байгууллагын дүрэм, журмыг мөрдөх;

2.2.8. гэрээний 5.4-д заасан үндэслэлээр гэрээг цуцалсан тохиолдолд олгосон санхүүжилтийг заасан хугацаанд буцаан төлөх;

2.2.9. төгсөөд, диплом олгосон өдрөөс хойш 2 сарын дотор санд бүртгүүлэх;

2.2.10. гадаадын сургалтын байгууллагад суралцан төгсөж ирээд 5 жил ажиллах боломжтой байх (өндөр насны болон цэргийн тэтгэвэр тогтоолгох насны хязгаар, төрийн тусгай албаны 20-25 жил ажилласан байх нөхцөлөөс үлдсэн хугацаа 10 жилээс доошгүй байх);

2.2.11.энэ гэрээнд заасан тогтоосон хугацаанд ажиллах шаардлагыг байгууллагын тодорхойлолт, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн баримтаар баталгаажуулна;

2.2.12 хууль тогтоомж, журмын хүрээнд харилцан тохиролцсон бусад.

2.3. Төрийн албан хаагч энэ гэрээний 2.2.2-т заасан хүндэтгэн үзэх шалтгаанаа эрх бүхий байгууллагын шийдвэрээр нотолно.

2.4. Сан дараах эрхтэй:

2.4.1.гэрээтэй холбоотой асуудлаар суралцагч (төрийн албан хаагч) болон төрийн байгууллагад санал, хүсэлт гаргах;

2.4.2.гэрээний үүргээ биелүүлэхийг төрийн албан хаагч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, төрийн байгууллагаас шаардах;

2.4.3 төрийн албан хаагчаас шаардлагатай тохиолдолд тайлбар, тодруулга авах;

2.4.4 хүний хувийн мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглах;

2.4.5.хууль тогтоомж, журмын хүрээнд харилцан тохиролцсон бусад.

2.5. Сан дараах үүрэгтэй:

2.5.1.тэтгэлгийг хичээлийн жилийн улирлаар тооцож, холбогдох шийдвэр, байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэлд үндэслэн сургалтын төлбөрийг сургалтын байгууллагын дансанд, дотуур байрны зардлыг хамаарах байгууллагын дансанд тус тус тогтоосон хугацаанд шилжүүлэх, шаардлагатай тохиолдолд тайлбар, тодруулга авах;

2.5.2.төрийн албан хаагчийн голч дүн, шилжилт хөдөлгөөн, тэтгэлэг олголтын талаар дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж, талуудыг үнэн зөв мэдээллээр хангах;

2.5.3.гэрээний биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах, хичээлийн жилийн улирал тутам дүгнэх, гэрээг түдгэлзүүлэх, сунгах, төрийн албан хаагч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд сангийн санаачилгаар гэрээг цуцалж, тэтгэлэг олгохыг зогсоох, өмнө олгосон санхүүжилтийг нэхэмжлэх, эргэн төлүүлэх, суутгах, журамд заасан үндэслэлээр гэрээг дуусгавар болгох;

2.5.4.хууль тогтоомж, журмын хүрээнд харилцан тохиролцсон бусад.

2.6. Төрийн байгууллага дараах эрхтэй:

2.6.1.гэрээтэй холбоотой асуудлаар суралцагч болон санд санал, хүсэлтээ илэрхийлэх;

2.6.2.төрийн албан хаагчид олгох тэтгэлгийн талаарх тайлбар, нэмэлт мэдээллийг сангаас авах;

2.6.3.тэтгэлгийг тогтоосон хугацаанд шилжүүлэхийг сангаас шаардах;

2.6.4.гэрээний үүргээ биелүүлэхийг төрийн албан хаагч болон сангаас шаардах;

2.6.5.төрийн албан хаагч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах саналыг санд тавьж шийдвэрлүүлэх;

2.6.6.хүний хувийн мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглах;

2.6.7.хууль тогтоомж, журмын хүрээнд харилцан тохиролцсон бусад.

2.7. Төрийн байгууллага дараах үүрэгтэй:

2.7.1.хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагчийн суралцах хугацаанд үндсэн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлөх;

2.7.2. төрийн албан хаагчийг төгсөж ирэхэд 3 сарын дотор мэргэжлийн дагуу ажлын байраар хангах, дэмжлэг үзүүлж ажиллах;

2.7.3. төрийн албан хаагчийг төгссөний дараа төрийн байгууллага өөрчлөн байгуулагдсан (нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх), эсхүл зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөн боловч түүний албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг хэвээр хадгалагдан үлдсэн бол албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах, хэрэв тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх албан тушаал (ажлын байр)-ын орон тоо цөөрсөн, хасагдсан зэрэг шалтгаанаар урьд ажиллаж байсан албан тушаалд үргэлжлүүлэн ажиллуулах боломжгүй тохиолдолд төрийн албан хаагчтай тохиролцон өмнөх нөхцөлийг дордуулахгүй өөр албан тушаалд сэлгэн ажиллуулах;

2.7.4. гэрээний хэрэгжилтийг хангуулах, биелэлтэд хяналт тавих;

2.7.5. гэрээг дүгнэхэд болон бусад шаардлагатай тохиолдолд санг шаардлагатай мэдээллээр хангах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;

2.7.6. хууль тогтоомж, журмын хүрээнд харилцан тохиролцсон бусад.

2.8. Төрийн албан хаагчтай биечлэн харилцах боломжгүй тохиолдолд аймаг/ хот, сум/ дүүрэг, баг/ хороо, гудамж/ хороолол, байр/хашаа, тоотод оршин суух, эцэг, /эх/-ийн нэр), (өөрийн нэр) нь түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч суралцагчийн адил үүргийг хүлээх болно болно.

2.9. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн бүрэн эрх Иргэний хуулийн 62 дугаар зүйлийн 62.3-т заасны дагуу итгэмжлэлийн үндсэн дээр үүснэ. Энэхүү итгэмжлэл нь гэрээний хавсралт байна.

ГУРАВ. ГЭРЭЭ СУНГАЛТ

3.1. Сан хичээлийн жилийн улирал бүр гэрээг дүгнэж, үүрэг биелсэн үед сунгана.

№	Хичээлийн жилийн улирал	Гэрээ дүгнэсэн огноо	Гэрээний хүчинтэй хугацаа	Сангийн Ажлын албаны дарга, гарын үсэг, тэмдэг	Төрийн албан хаагч (итгэмжлэгдсэн төлөөлөгч)-ийн нэр, гарын үсэг
1					
2					
3					
4					
5					
6					
7					
8					
9					
10					

ДӨРӨВ. ТЭТГЭЛЭГ ОЛГОЛТ

4.1 Сан гэрээний хугацаанд олгосон тэтгэлгийг (олгосон валютаар)-ийг тухайн улиралд баталгаажуулна

№	Хичээлийн жилийн улирал	Голч дүн	Хамаарах зардал		Төрийн албан хаагч (итгэмжлэгдсэн төлөөлөгч)-ийн нэр, гарын үсэг	Сангийн мэргэжилтэн нэр, гарын үсэг	Тайлбар
			Сургалтын төлбөрийн хэмжээ	Дотуур байрын зардлын хэмжээ			
1							
2							
3							
4							
5							
6							
7							
8							
9							
10							

ТАВ. ГЭРЭЭГ СУНГАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ЦУЦЛАХ, ДУУСГАВАР БОЛГОХ

5.1. Гэрээг хичээлийн жилийн улирлаар дүгнэж, дараах тохиолдолд сунгана:

5.1.1.Төрийн албан хаагчийн өмнөх улиралд судалсан хичээлүүд нь тухайн үнэлгээний системийн дагуу хангалттай буюу түүнээс дээш түвшинд үнэлэгдсэн"

5.1.2.гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлсэн байх.

5.2.Гэрээг хичээлийн жилийн улирлаар дүгнэж, дараах тохиолдолд түдгэлзүүлж, тэтгэлэг олгохыг зогсооно:

5.2.1.төрийн албан хаагч жирэмсний, амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй, эсхүл хүндэтгэн үзэх шалтгааны улмаас 1 сараас дээш хугацаагаар суралцах боломжгүй болсныг эрх бүхий байгууллагын шийдвэрээр нотолсон тохиолдолд;

5.2.2.дүнгийн шаардлага хангаагүй;

5.2.3.төрийн албан хаагч сургалтын байгууллагаас хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөө авсан.

5.3.Суралцах хугацаанд гэрээг 2 удаа түдгэлзүүлж болох ба түдгэлзүүлэх нийт хугацаа 2 жил хүртэл байна. Хугацаа хэтэрсэн тохиолдолд гэрээг цуцална.

5.4.Гэрээг дүгнэж, дараах тохиолдолд аль нэг талын санаачилгаар цуцална:

5.4.1.төрийн албан хаагч гэрээнд заасан суралцах улс, сургалтын байгууллага, мэргэжил өөрчилсөн;

5.4.2.суралцуулах шийдвэрээр баталсан хугацаанд төгсөөгүй, түдгэлзүүлэх хугацаа хэтэрсэн;

5.4.3. төрийн албан хаагч сургалтын байгууллагаас хасагдсан, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гарсан, шалтгаангүйгээр чөлөө авсан, чөлөөний хугацаа сунгасан;

5.4.4. төрийн албан хаагч хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь баримтаар тогтоогдсон;

5.4.5. төрийн албан хаагч суралцах хугацаандаа гэмт хэрэгт холбогдож, гэм буруутайг нь шүүхээс тогтоосон;

5.4.6. төрийн албан хаагч төгсөөд жирэмсний, амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй, хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд 6 жилийн дотор ажилд ороогүй, эсхүл энэ гэрээний 2.2.10-д заасны дагуу ажиллаагүй;

5.4.8 Суралцагч хөтөлбөрөөс татгалзсан;

5.4.9 гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй.

5.5. Гэрээг түдгэлзүүлэх, цуцлахад талууд баримт үйлдэж, гэрээнд хавсаргана.

5.6. Гэрээний 5.4.-д заасан үндэслэлээр цуцалсан тохиолдолд төрийн албан хаагч олгосон тэтгэлгийн нийт санхүүжилтийг 2 жилийн дотор тэтгэлэг олгосон валютаар буцаан төлнө. Энэ тухай мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор буцаан төлөх хуваарийг төрийн албан хаагчтай тохиролцож тогтооно.

5.7. Дараах үндэслэлээр гэрээ дуусгавар болно:

5.7.1. гэрээний хугацаа дуусаж, талууд хүлээсэн үүргээ биелүүлсэн байх;

5.7.2. төрийн албан хаагч нас барсан, нас барсан гэж шүүхээс зарласан, сураггүй алга болсонд, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүй гэж шүүхээс тооцсон, хөдөлмөрийн чадвараа алдсаныг Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэрээр тогтоосны дагуу даатгалын гэрээнд заасны дагуу гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулсан;

5.7.3. аль нэг талын санаачилгаар хугацаа дуусахаас өмнө гэрээг цуцалж, гэрээний үүргийг биелүүлсэн.

5.8. Энэ гэрээнд заасан "хөдөлмөрийн чадвараа алдсан" гэснийг холбогдох хууль, журамд заасны дагуу ойлгоно.

5.9. Сан энэ гэрээг 5.4-т заасан гэрээг цуцлах нөхцөл байдал үүссэн даруйд цуцлаагүй нь энэ эрхээ хэрэгжүүлэхээс татгалзсан гэж үзэхгүй.

5.10. Төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтанд энэ гэрээний 2.7.1-2.7.3-т заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ЗУРГАА. БУСАД

6.1. Гэрээг гурван хувь үйлдэх бөгөөд хувь тус бүр адил хүчинтэй байна.

6.2. Энэ гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга/ тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

6.3. Гэрээ хүчин төгөлдөр болсноор төрийн албан хаагчид санхүүжилтийг олгоно.

6.4. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр холбогдох хууль тогтоомж, журмын хүрээнд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Холбогдох нэмэлт, өөрчлөлт нь энэ гэрээний 1.4-т хамаарахгүй.

6.5. Гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

6.6. Талуудын хооронд гэрээнд заасан асуудлаар маргаан гарвал зөвшилцлийн замаар шийдвэрлэхийг урьтал болгох бөгөөд зөвшилцөлд хүрч эс чадвал шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Төрийн албан хаагч:	Төрийн байгууллагыг төлөөлж	Санг төлөөлж Ажлын албаны дарга
..... (эцэг/эх-ийн нэр) (эцэг/эх-ийн нэр) (эцэг/эх-ийн нэр)
..... (өөрийн нэр) (өөрийн нэр) (өөрийн нэр)
..... (гарын үсэг) (гарын үсэг) (гарын үсэг)

Итгэмжлэгдсэн төлөөлөгч:

.....
(эцэг/эх-ийн нэр)

.....
(өөрийн нэр)

.....
(гарын үсэг)

20 ... оны ... дугаар сарын ... өдөр